

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2024/65/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2024 он	Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл Утас: 70422954 Цахим хаяг: J_aigul@yahoo.com Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: NazgulD@audit.gov.mn “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: В.Хуандых Утас: 99426960 Цахим хаяг: khuash69@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

БӨА-2024/65/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан

 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
22 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ш.МӨНХЖАРГАЛ ТАНАА

2024.02.06 № 40
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд онцлох асуудал гараагүй байна.

Аудитын гол асуудал

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторовын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Өлгий 22-р цэцэрлэг Дүгнэлт-2.06

БӨА-2024/65/НА-СТА-ТШЗ

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

Өлгий 22-р цэцэрлэг Дүгнэлт-2.06

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	51414418.00	191429691.42
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	41293741.00	179335557.42
31211	Төрийн сангийн харилцах	41293741.00	179335557.42
35	БАРАА МАТЕРИАЛ	10120677.00	12094134.00
35420	Аж ахуйн материал	8618200.00	10682500.00
35460	Хүнсний материал	1475477.00	1411634.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10016266.62	24249206.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10016266.62	24249206.42
391	Газар	0.00	0.00
392	Биет хөрөнгө	9414933.35	22495516.79
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5353000.00	9804000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1292266.61	-2667516.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	6474000.00	18058000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1119800.04	-2698966.71
393	Биет бус хөрөнгө	601333.27	1753689.63
39301	Програм хангамж	880000.00	2303239.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-278666.73	-549549.37
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	61430684.62	215678897.84
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	61430684.62	215678897.84
51	Засгийн газрын хувь оролцоо	61430684.62	215678897.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.00	0.00
51101	Өмч: - төрийн	0.00	0.00
512	Хуримтлагдсан үр дүн	61430684.62	215678897.84
51210	Өмнөх үеийн үр дүн	61430684.62	61430684.62
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	154248213.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	61430684.62	215678897.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	241,475,800.00	611,111,839.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	17,363,239.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	17,363,239.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	241,475,800.00	593,748,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	232,563,500.00	589,248,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	232,563,500.00	589,248,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103,500.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	8,808,800.00	4,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	8,808,800.00	4,500,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	199,640,085.60	456,863,625.78

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

21	УРСГАЛ ЗАРДАЛ	199,640,085.60	456,863,625.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	199,358,585.60	456,863,625.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	148,899,025.00	330,966,043.58
210101	Үндсэн цалин	148,899,025.00	246,931,356.31
210102	Нэмэгдэл	-	75,018,740.07
210104	Урамшуулал	-	9,015,947.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,271,784.00	62,553,100.00
210201	Тэтгэврийн даатгал	13,156,219.00	42,536,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,547,790.00	5,004,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,218,073.00	4,003,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	304,519.00	1,000,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,045,183.00	10,008,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	4,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	76,500.00	-
210401	Бичиг хэрэг	76,500.00	-
2105	Нормативт зардал	23,837,126.60	47,474,983.00
210502	Хоол, хүнс	23,837,126.60	47,474,983.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165,000.00	690,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165,000.00	690,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,109,150.00	10,678,999.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,187,750.00	5,490,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,555,000.00	1,963,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,366,400.00	3,225,299.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	281,500.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	281,500.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,835,714.40	154,248,213.22
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,835,714.40	154,248,213.22

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	241475800.00	593748600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	232563500.00	589248600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	232563500.00	589248600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	103500.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	103500.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	8808800.00	4500000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	8808800.00	4500000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	199307059.00	455611783.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199307059.00	455611783.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	199025559.00	455611783.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	146249509.00	330966043.58
210101	Үндсэн цалин	125265404.00	246931356.31
210102	Нэмэгдэл	19626305.00	75018740.07
210104	Урамшуулал	1357800.00	9015947.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21921300.00	62553100.00
210201	Тэтгэврийн даатгал	14906200.00	42536100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1753800.00	5004300.00

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

210203	ҮОМШӨ-ний даатгал	1402900.00	4003400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	350900.00	1000800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3507500.00	10008500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	4500000.00
210301	Гэрэл, цахилгаан		4500000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103500.00	0.00
210401	Бичиг хэрэг	103500.00	
2105	Нормативт зардал	24035100.00	47371140.00
210502	Хоол, хүнс	24035100.00	47371140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	165000.00	690500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	165000.00	690500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6551150.00	9531000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5051150.00	7486500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1500000.00	2044500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	281500.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	281500.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	42168741.00	138136816.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	875000.00	95000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	875000.00	95000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-875000.00	-95000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	41293741.00	138041816.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		41293741.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	41293741.00	179335557.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			61,430,684.62		61,430,684.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	61,430,684.62	0.00	61,430,684.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн					0.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	61,430,684.62	0.00	61,430,684.62
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	61,430,684.62	0.00	61,430,684.62
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	61,430,684.62	0.00	61,430,684.62
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			154,248,213.22		154,248,213.22
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	215,678,897.84	0.00	215,678,897.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	635042300.00	455706783.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	635042300.00	455706783.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635042300.00	455706783.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	505351900.00	330966043.58
210101	Үндсэн цалин	335786300.00	246931356.31
210102	Нэмэгдэл	156949400.00	75018740.07
210104	Урамшуулал	12616200.00	9015947.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63168800.00	62553100.00
210201	Тэтгэврийн даатгал	42955000.00	42536100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5053400.00	5004300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4042800.00	4003400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1010600.00	1000800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10107000.00	10008500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4500000.00	4500000.00
210301	Гэрэл, цахилгаан	4500000.00	4500000.00
2105	Нормативт зардал	51612500.00	47371140.00
210502	Хоол, хүнс	51612500.00	47371140.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690500.00	690500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	690500.00	690500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9718600.00	9626000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7674100.00	7581500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2044500.00	2044500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	635042300.00	593748600.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	589248600.00	589248600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	589248600.00	589248600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4500000.00	4500000.00
132001	Орон нутгийн төсвөөс	4500000.00	4500000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	41293700.00	0.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	41293700.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		41293741.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		179335557.42
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	43.00	35.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	23.00	22.00
620003	Үйлчлэх ажилтан	19.00	12.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43.0	35.0
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	24.00	23.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19.00	12.00

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэг нь тайлант онд “Хүүхдийн аюулгүй ээлтэй орчинд сурах таатай орчныг бүрдүүлж эх оронч, хүнлэг бүтээлч монгол хүүхдийг бэлтгэх” зорилт, “Хүүхэд нэг бүрийн хүсэл сонирхлыг хүндэтгэн үзэж, тэдний сурч хөгжих, төлөвших сургалтын таатай орчин бүрдүүлэх” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Улсын Их хурлаас 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль хуулийг шинэчлэн баталсан байна.

Засгийн газрын 2023 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн сүлжээнд үнэмлэхгүй хэмжээний өөрчлөлт орсон.

Сангийн сайдын 2023 оны 65 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар аккруэл суурьт УСНББОУС-ыг нэвтрүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсролын ерөнхий газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг. Боловсролын ерөнхий газраас байгууллагын сургалтын алба болон санхүүгийн материалын шалгалт хийсэн. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн баримтад баримтын шалгалт хийсэн байна.

Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй ба захирлын тушаалаар батлагдсан журам, зааврын дагуу төлөвлөгөөт дотоод хяналт шалгалт хийдэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 154.2 сая төгрөгөөр буюу 351.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	412,93.7	179,335.6	138,041.9
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	10,120.7	120,94.1	1,973.4
Үндсэн хөрөнгө	10,016.3	24,249.2	14,232.9
Нийт хөрөнгө	61,430.7	215,678.9	154,248.2
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	61,430.7	215,678.9	154,248.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	61,430.7	215,678.9	154,248.2

Мөнгөн хөрөнгө оны эцэст 179.3 сая төгрөг үлдэгдэлтэй гарч оны эхнээс 138.0 сая төгрөгөөр өссөн ба 175.0 сая төгрөг нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, 4.3 сая төгрөг нь хүүхдийн хоолны зардлаас үлдсэн мөнгө байна.

Бараа материал данс оны эцэст 12.1 сая төгрөг болж оны эхнээс 2.0 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: хүнсний материал 1.4 сая төгрөгийн, аж ахуйн материал 10.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 24.2 сая төгрөг болж 14.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгийн санхүүжилтээр 17.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгөнд 3.2 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 215.7 сая төгрөг болж 152.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 154.2 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Цэцэрлэгийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 230.2 сая, орон нутгийн төсвөөс 4.5 сая, нийт зарлагыг 234.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас цэцэрлэгийн 2023 оны хувьсах зардлын төсвийг 473.0 сая төгрөгөөр хянаж, 238.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан ба төсвийн тодотголоор 116.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 589.2 сая төгрөг болгон тодотгон баталжээ.

Орон нутгийн төсвөөс авах тогтмол зардлын төсвийг 4.5 сая төгрөгөөр баталсан ба өөрчлөлт ороогүй байна.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 589.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 4.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс нийтдээ 593.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 589.2 сая, орон нутгийн төсвөөс 4.5 сая нийтдээ 593.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 41.3 сая төгрөгийг оны эхний үлдэгдлээс зарцуулсан байна. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 455.7 сая төгрөг буюу 71.7 хувьтай байгаа нь 179.3 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эрүүл мэндийг дэмжих	1,035.8	1,035.8	0	100%
2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	51,612.5	47,371.1	4,241.4	91.8%
3	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,929.3	1,929.3	0	100%
4	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	1,035.8	1,035.8	0	100%
5	Боловсролын стандарт, сургалтын	417,351.1	304,482.5	112,868.6	73%
6	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	157,577.8	95,444.8	62,133.0	60.6%
7	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	4,500.0	4,500.0	0	100%
	Нийт дүн	635,042.3	455,706.8	179,335.6	71.7%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Цэцэрлэг нь тайлант онд нэмэлт төсөв аваагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгт 2023 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэг нь 2023 онд батлагдсан төсвийн хүрээнд 52.9 сая төгрөгийн бараа материал худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, байгууллагын үйл ажиллагааг

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ний аудитор В.Хуандых гүйцэтгэж, анхан шатны хяналтыг “Уужим алтай Аудит” захирал Б.Галымбек, дараагийн шатны хяналтыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар хэрэгжүүлсэн.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардал сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 199.6 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 3.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 456.9 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 9.1 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах асуудлын хүрээнд тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 29 шалгуур үзүүлэлтээр горим сорил хэрэгжүүлсэн. Алдаа, зөрчил илрээгүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг бүрэн мэдээлсэн байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100%-тай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар цэцэрлэгийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 17.4 сая төгрөгийн орлогыг буруу тайлагнасныг залруулсан ба Аудитаар нийт 7.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрч зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цэцэрлэгийн цалингийн зардлын төсвөөс ажилтнуудад 7.7 сая төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал"-тай нийцээгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу зардлын эдийн засгийн ангиллыг мөрдөж, батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар төлөвлөж, зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь төрийн аудитын газарт 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд үнэгүй ирсэн хөрөнгийг буруу тайлагнасан	1	17,363.2					1	17,363.2				
Дүн	1	17,363.2					1	17,363.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалингийн зардлаас ажилтнуудад түлээ нүүрсний хөнгөлөлт Сангийн сайдын тушаалаар баталсан журмыг мөрдөөгүй.	1	7,650.0					1	7,650.0				
Дүн	1	7,650.0					1	7,650.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Зөвлөмж	
							Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										

Өлгий сумын хүүхдийн 22 дугаар цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлангийн
аудит

Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								